

# ҮНДСЭН ХУУЛЬ

## ҮНДСЭН ОЙЛГОЛТ



## ҮНДСЭН ХУУЛЬ

Бидний өдөр тутмын амьдралыг зохицуулж байдаг хэм хэмжээг ХУУЛЬ гэдэг. Бүх хуулийг нэг том саглагар мод байна гэж төсөөлцгөөе!

Энэ модны үндэс нь Үндсэн хууль бол түүний салаа мөчрүүд нь бусад хуулиуд юм. Өөрөөр хэлбэл, Үндсэн хууль бол бусад хуулиудын эх ундарга бөгөөд хамгийн дээд хүчин чадалтай, хамгийн гол хууль юм. Бусад бүх хууль Үндсэн хуульд нийцэж байх ёстой.



Дэлхийн бүх улс оронд Үндсэн хууль бий. Улс орнууд Үндсэн хуульдаа өөрийн улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутаг, хүн ард, соёл, зан заншил зэрэг бүхий л үнэт зүйлээ хамгаалахаар заасан байдаг. Мөн Үндсэн хууль нь хүний үндсэн эрх, эрх чөлөөний баталгаа болохоос гадна тухайн улсын төрийн байгууллагын тогтолцоог хуульчилсан байдаг. Иймээс Үндсэн хуульд нийцээгүй хуулийг хүчингүйд тооцно.

Одоо мөрдөж буй Үндсэн хуулийг 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр баталжээ. Энэ Үндсэн хуулийг анхны **АРДЧИЛСАН Үндсэн хууль** гэж нэрлэдэг.

Монгол Улсын Ардчилсан Үндсэн хууль Оршил, 6 бүлэг, 70 зүйлтэй.

**ОРШИЛ**

Монгол Улсын ард түмэн бид эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгож буйгаа тунхагласан байна.



**1-Р БҮЛЭГ**

Монгол Улс бол бүрэн эрхтэй, тусгаар тогтносон, бүгд найрамдах улс гэдгийг баталгаажуулжээ.



**2-Р БҮЛЭГ**

Монгол Улсын иргэн бүрийн баталгаатай эдлэх эрх, эрх чөлөөг тусгасан. Мөн иргэн бүрийн хүлээх үндсэн болон журамт үүргийг тогтоожээ.



**3-Р БҮЛЭГ**

Монгол Улсын төрийн удирдах, дээд байгууллагуудын тухай заасан байна. Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Шүүх нь төрийн эрх мэдлийн дээд байгууллагууд юм.



**4-Р БҮЛЭГ**

Монгол Улс аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана. мөн эдгээр нэгжүүдийг хэрхэн удирдан жолооддог тухай энэ бүлэгт бий.



**5-Р БҮЛЭГ**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай энэ бүлэгт тусгасан.



**6-Р БҮЛЭГ**

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай заалтуудыг тусгасан байдаг.



## ҮНДСЭН ХУУЛЬ БА БИДНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

Манай улсын Үндсэн хуульд монголчууд бидний эрхэмлэдэг үнэт зүйлс, тухайлбал улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх, соёлын уламжлал зэргийг хамгаалсан олон заалт бий.



Эдгээрээс хамгийн түрүүнд Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлэгт заасан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хүүхдүүд бид маш сайн ойлгож мэдэх ёстой.

Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэн бүр дараах эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэхээр заасан байдаг.



Амьд явах эрхтэй.

Манай улс хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлж байгаа тул хүн бүрийн амь насыг эрхэм дээд үнэт зүйлд тооцож Эрүүгийн хуулиас цаазаар авах ялыг халсан.



Эрэгтэй, эмэгтэй бүх хүн тэгш эрхтэй.

Эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд ч нэгэн адил тэгш эрхтэй. Урлаг, спортын болон сургуулийн бүхий л үйл ажиллагаанд эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд яг ижил тэгш байдлаар оролцох эрхтэй.

Ямар амьдралаар амьдрах, амьдралын хэв маягаа сонгох тал дээр эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн хооронд ямар ч ялгаа байхгүй.



Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй.

Бидний сургууль, тоглоомын талбайг үргэлж цэвэрлэдэг. Бид ч мөн хуваарь гаргаж анги танхимаа цэвэрлэдэг.



Бид сурч боловсрох эрхтэй.

Ямар гэр бүлд төрсөн, эсхүл ямар нөхцөлд амьдардгаас үл хамааран хүүхэд бүрт ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгох үүргийг Монголын төр хүлээдэг.



Танай сургууль дээр хүүхдүүдэд вакцин хийж байсан уу? Өвдсөн үедээ сургуулийн эмчид очиж үзүүлж, эмнэлгийн тусламж авч байсан уу?

Үндсэн хуульд Монгол Улсын иргэн бүр "эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй" гэж заасан байдаг юм шүү дээ.



Чи том болоод ямар ажил хийхийг мөрөөддөг вэ?



Үндсэн хуульд биднийг "Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхтэй" хэмээн тунхагласан байдаг. Өөрөөр хэлбэл та нарын хүссэн мэргэжлээ эзэмшиж, дуртай ажлаа хийх боломжийг Үндсэн хуулиар олгосон.



Чи хүссэн мэргэжлээ эзэмшээд ажил хөдөлмөр эрхлэхийг хүсдэг биз дээ?



Тэгвэл ажиллах орчин аюулгүй, эрүүл мэндэд ээлтэй байх ёстой. Иймээс, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхийг ч мөн Үндсэн хуульд заасан байдаг.

Би өдөр бүр өдрийн тэмдэглэл хөтөлдөг.



Хүүхдүүд ээ! та нар найзынхаа хувийн нууцыг тохиолдлоор мэдсэн бол бусдад ярьж задруулж болохгүй шүү!



Ардчилсан нийгэмд хувь хүний нууцыг хуулиар хамгаалдаг. Чиний найздаа бичсэн захидал, өдрийн тэмдэглэл зэргийг чиний зөвшөөрөлгүйгээр унших эрх хэнд ч байхгүй.

Миний бодлоор...



Иргэн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрх чөлөөтэй.

Хүүхэд бүр юу бодож буйгаа чөлөөтэй илэрхийлэх, өөрийн сонирхож буй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхтэй.



Манай ангийн Орчлон багадаа Солонгост амьдарч байхдаа гэр бүлээрээ Христийн шашинд итгэгч болсон гэсэн. Харин би эмээ өвөөгийнхөө шүтдэг Бурхны шашныг шүтдэг. Мөн ямар ч шашин шүтдэггүй хүүхдүүд ч байдаг.

Бид бие биеийнхээ шашин шүтлэг, итгэл үнэмшлийг өөрсдийнхөөсөө ялгаатай байсан ч хүндэтгэх хэрэгтэй.



Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй.



Манай гэр бүл өнгөрсөн зуны амралтаар эх орныхоо үзэсгэлэнт газруудаар явж аялсан.



Манай ах АНУ-ын Калифорни мужид их сургуульд сурч байгаа бөгөөд өвлийн амралтаар гэртээ ирнэ.

## ҮНДСЭН ХУУЛЬ БА БИДНИЙ ҮҮРЭГ

Бид өөрсдийн үндсэн эрх, эрх чөлөөний заримтай нь танилцлаа. Хүний эрх нь хүн бүрд хамаатан нэгэн адил хүн бүрийн хүлээх ёстой үүрэг гэж бий. Үндсэн хуульд бидний **ҮНДСЭН БОЛОН ЖУРАМТ ҮҮРГИЙГ** заажээ.

### Үндсэн үүрэг

Үндсэн үүргийг бид хүссэн ч, эс хүссэн ч заавал биелүүлэх ёстой. Хэрвээ биелүүлээгүй бол хуулийн хариуцлага хүлээнэ.



Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх үүрэгтэй.



Аав ээжүүд сар бүр цалингаасаа татвар төлдөг. Учир нь хүн бүр хуулиар ногдуулсан албан татвар төлөх үүрэгтэй.



Найз нөхөд, багш нарынхаа талаар худал зүйл ярьж, бусдад тарааж болохгүй шүү. Бид хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх үүрэгтэй.

Манай ах энэ жил сургуулиа төгсөөд цэргийн алба хаахаар явсан. Учир нь бид эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах үүрэгтэй.



## Журамт үүрэг:



Журамт үүрэг нь хүний ухамсар, мөс чанарт үндэслэсэн байдаг.



Бид эх орон, байгаль орчноо хайрлан хамгаалах үүрэгтэй.

Эцэг эх бүр үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, хайрлах үүрэгтэй.



Төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандинган өвлөх, хүндэтгэх үүрэгтэй.



Эрүүл мэндээ хамгаалах үүрэгтэй.




# ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

Манай улс жил бүрийн 1 дүгээр сарын 13-ны өдрийг Үндсэн хуулийн өдрөө болгон тэмдэглэдэг. Дэлхийн олонх улс орон Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэлт өдөр болгосон байдаг.

Жишээ нь: АНУ-ын хувьд жил бүрийн 9 дүгээр сарын 17-ны өдөр, ОХУ-д 12 дугаар сарын 12-ны өдөр, Япон улс 5 дугаар сарын 3-ны өдрийг Үндсэн хуулийн өдөр болгон тэмдэглэдэг.



**1 САРЫН 13**  
МОНГОЛ  
УЛС



**12 САРЫН 12**  
ОРОСЫН  
ХОЛБООНЫ  
УЛС



**5 САРЫН 3**  
ЯПОН  
УЛС



**9 САРЫН 17**  
АМЕРИКИЙН  
НЭГДСЭН  
УЛС




## ТҮЛХҮҮР ҮГ



- ✓ Үндсэн хууль
- ✓ Хууль

- ✓ Хүний эрх
- ✓ Эрх чөлөө

- ✓ Үндсэн үүрэг
- ✓ Журамт үүрэг



## ДАСГАЛ АЖИЛ



Үндсэн хуульд заасан эрх, үүргийг хүснэгтээс олоорой! Үүний дараа тухайн эрх, үүргийг жишээгээр тайлбарлаарай.

Д	Ё	З	Ч	Ө	Л	Ө	Ө	Т	Э	Й	З	О	Р	Ч	И	Х
Э	М	Э	Р	Г	Э	Ж	Л	Э	Э	С	О	Н	Г	О	Х	И
Т	Х	Ы	А	А	Я	О	Б	Ж	Л	Н	О	Ө	У	Б	Ө	Х
Ү	Ч	О	Ш	А	Ш	И	Н	Ш	Ү	Т	Э	Х	Х	Ч	Д	Д
Ы	Э	Ц	В	А	Ё	Й	А	Ь	М	П	Ф	Т	П	И	Ө	У
И	Ц	Ь	А	М	Ь	Д	Я	В	А	Х	Б	С	И	И	Л	Т
Т	Р	О	М	Р	О	Д	Я	К	П	А	Б	Ж	З	М	М	Ш
Д	Э	Д	М	Х	Ф	Т	А	Т	В	А	Р	Т	Ө	Л	Ө	Х
Ө	М	Ч	М	Б	М	Ь	Ь	А	Ф	Ө	Д	Ф	Э	Х	Р	Х
Ц	Э	Р	Г	И	Й	Н	А	Л	Б	А	Х	А	А	Х	Л	А
Х	Т	Х	Р	О	З	Й	У	Х	Н	Х	Ч	Ф	Ы	Б	Ө	В
Т	Т	Й	С	У	Р	Ч	Б	О	Л	О	В	С	Р	О	Х	Э
Г	Х	Ү	Н	Б	Ү	Р	Т	Э	Г	Ш	Э	Р	Х	Т	Э	Й



## ХЯНАЛТЫН АСУУЛТ



1. Үндсэн хууль гэж юу вэ?
2. Үндсэн хуулийн бүтэц, агуулгыг өөрийн үгээр тайлбарлана уу.
3. Хүний эрх, эрх чөлөөг яагаад заавал Үндсэн хуулиар баталгаажуулдаг вэ?
4. Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг бичнэ үү.